

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 02 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын дарга зарим сумдад ажиллаж Улсын сайн малчин, Алтан төлийн эзэн, аймгийн аварга малчин, аймгийн алдарт уяачдын шагнал болон Төрийн дээд одон медалиар шагнагдсан иргэд, 2017 оны салбарын тэргүүний ажилчдын шагналыг гардууллаа.

ИТХ-аас зарим албан байгууллагуудтай хамтран бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх МУ-ын Засгийн газрын 05 дугаар тогтоол Аймгийн Засаг даргын 2017 оны А/28 тоот захирамжийг хэрэгжүүлэх Үндэсний уламжлалт "Мөсний шагайн" наадгайг сурталчлан дэлгэрүүлэх, албан байгууллага ард иргэдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор зохион байгуулсан "Мөсний баяр"-ын арга хэмжээг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслөөс иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналтын болон төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжих ээлжит тэтгэлэгт хөтөлбөр зарлагдсаныг сумдын ИТХуралд мэдээллэв.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 1/516 тоот албан бичгийн дагуу Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд хийсэн ажлын тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, аймаг, сумын ИТХ, багийн ИНХ-ын хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг гаргаж Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэв.

Ашигт малтмал, газрын тосны газраас 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 7/627 дугаар албан тоот Ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой гэсэн мэдэгдлийн хавсралтанд заагдсан солбицол бүхий талбайд байрших 16 сумын 381.790.06 гектор талбайн саналыг авч хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицолтой холбоотой мэдээллүүдийг холбогдох байгууллагуудыг оролцуулан ажлын хэсэг байгуулж 2017 оны 03-р сарын 02-ны дотор ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст чиглэл өгч ажиллаа.

Аймаг сумдын эмэгтэй Төлөөлөгчдөд зориулсан сургалтыг "Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төсөл "МонФемНет" ТББ-тай хамтран зохион

байгуулахаар төлөвлөж байгаатай холбогдуулан сургалтанд хамрагдах 24 сумдын 98 төлөөлөгчийн бүртгэл судалгааг урьдчилан авч нэгтгэв.

Сумдын ИТХ-ын 2017 оны ажлыг ажлын хэсэг гаргаж 2015 оны ИТХТэргүүлэгчдийн 95 тоот тогтоолоор баталсан Сумдын ажлыг дүгнэх журмын дагуу 22 үзүүлэлтээр дүгнэж 1-р байранд Улиастай, 2-р байранд Отгон, 3-р байранд Тэлмэн сум тус тус шалгарлаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 95 дугаар тогтоолоор сумдын ажлыг дүгнэх журмын дагуу сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2017 онд хийсэн ажлыг дүгнэсэн.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой Яруу, Алдархаан, Цагаанхайрхан сумдын иргэнээс нөхөн олговор авах, хэлмэгдэгчдийн ар гэр болох үр хүүхдэд нөхөн олговор олгох талаар ирүүлсэн өргөдлийг хүлээн авч арга зүйн зөвлөгөө өгч холбогдох газарт уламжлан хариуг иргэнд хүргүүлж ажиллалаа.

Завхан аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооноос ЕБС-ийн ахлах ангийн суралцагчдын дунд зохион байгуулсан “Бид ирээдүйн хөдөлмөрчид” сэдэвт эссэ бичлэгийн уралдааны хоёрдугаар үе шат иргэний танхимд зохион байгуулагдаж, шалгарсан 7 суралцагч оролцов.

Иргэний нийгмийн өдрөөр аймгийн төрийн бус байгууллагууд уулзалт зохион байгуулж хамтран ажиллах санал солилцсон. Төрийн бус байгууллагын 20 төлөөлөл оролцсон.

НҮБ-ын хүний эрхийн зөвлөлийн хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс өгсөн зөвлөмжийн дунд хугацааны хэрэгжилтийг үнэлэх хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа.

Аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхимаас бизнес эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулж Эрдэнэт хотод болох үзэсгэлэн худалдааны талаар санал солилцлоо.

Иргэний танхимд цаг үеийн цахим хурал 2 удаа зохион байгуулагдаж иргэд, албан хаагчид мэдээ мэдээлэл, заавар чиглэл авч ажилласан.Хуралд нийт 65 иргэд, албан хаагчид оролцов.

## **1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2018 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлууллаа. 2 дугаар сард Засаг даргын зөвлөлийн хурлыг хийж, аймгийн тэргүүний сум, баг, хэлтэс агентлаг, тэргүүний ажилтан, аймгийн аварга малчин, аймгийн Алдарт уяач, хоршоо, тариаланчийг шалгаруулах зэрэг асуудлыг тус тус хэлэлцлээ.

XVII жарны Тийн унжлагат хэмээх Шар нохой жилийн өмнө оны тэргүүнээр шалгарсан төрийн албан хаагчид, төрийн байгууллага, аймгийн сайн малчин, алдарт уяач, тэргүүний тариаланч, сум, багийн шагналыг гардуулах ажлыг зохион байгуулж, ахмад настангууддаа хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг өглөө.

2017 оны үйл ажиллагаагаараа агентлагуудаас тэргүүн байрыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, дэд байрыг Орон нутгийн өмчийн газар, гутгаар байрыг Онцгой байдлын газар, сумдаас тэргүүн байрыг Сонгино сум, дэд байрыг Нөмрөг сум, гутгаар байрыг Тэлмэн сум, багуудаас тэргүүн байрыг Тосонцэнгэл сумын Хайрхан баг, дэд байрыг Баянхайрхан сумын Асгат баг, гутгаар байрыг Цагаанчулуут сумын Дэлгэр баг, Эрдэнэхайрхан сумын Багануур баг тус тус эзэллээ.

Мөн аймгийн аварга малчнаар 24 сумын 94 малчин, алтан төлийн эзнээр 11 малчин, Улсын аварга малчнаар 9 сумын 9 малчин, улсын аварга тариаланчаар 1 сумын 1 тариаланч, Улсын аварга саальчнаар 1 сумын 1 саальчин, аймгийн алдарт уяачаар 9 сумын 13 уяач тус тус шалгарлаа.



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга Ө.Энхтүвшингээр ахлуулсан “**шуурхай бүлэг**” Завхан аймгийн өвөлжилт хүндэрсэн Сонгино, Түдэвтэй, Тосонцэнгэл сумдад ажиллаж нөхцөл байдалтай газар дээр нь биечлэн танилцлаа.

Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолоор тус аймгийн УНСалбар цэгүүдээс 450 тн өвс үнэгүй, 760 тн тэжээлийн 50 хувь хямдруулж, Өвөлжилт хүндэрсэн 9 сумдад 260 тн өвс үнэгүй, 130 тн тэжээлийн 50 хувь хямдруулан Түдэвтэй, Тосонцэнгэл сумдад нэгдсэн зохион байгуулалттай сумдын Засаг дарга нарт хүлээлгэн өглөө.



Улсын Онцгой комиссын Шуурхай бүлэгт Завхан аймгийн Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын газрын дарга хурандаа Ө.Болд 2017-2018 оны өвөлжилтийн нөхцөл байдал, орон нутгаас авч хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл хийж аймгийн онцгой комиссыг хуралдуулсан.

Улсын Онцгой комиссын 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрээр тус аймгийн Улсын нөөцийн салбар цэгүүдээс 850 тн өвс үнэгүй, 1150 тн тэжээлийг 50 хувь хямдруулан олгохоор шийдвэрлэж Яруу, Дөрвөлжин сумдын Эрүүл мэндийн төв, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашиныг хүлээлгэн өглөө.

## **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**2.1.Төсвийн гүйцэтгэл:** Аймгийн хэмжээгээр 2018 оны 1 сард 6 тэрбум 458,2 сая төгрөг төсөвлөгдсөнөөс 3 тэрбум 359,2 сая төгрөгийн зарлага гарсан байна.

Монгол банкны мэдээгээр эхний 1 сард гүйлгээнд 170.7 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 64.6 мянган иргэний 70.2 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 7.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн дүнгээр эхний 1 дүгээр сард 12.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оноос 3.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.8 хувь, Хас банк 0.58-2.0 хувь, Төрийн банк 1.5 хувь, Капитал банк 1.5 хувь байна.

**2.2. Татвар төлөлтийн байдал:** Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 159.9 хувийн биелэлттэй, 849.8 сая төгрөгийн орлого оруулж, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 32.4 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 2.3 хувь, ашигт малтмал ашигласаны төлбөр 39.1 хувь, бусад нэр төрөл 26.2 хувийг эзэлж байна.

## **Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:**

**3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа:** Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 21 аймгийн Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийн гишүүдийн цахим хуралд оролцсон.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтын явцын талаар Нэгдсэн үндэсний байгууллагын хүний эрхийн зөвлөлийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс Монгол улсын засгийн газарт өгсөн зөвлөмжийн дунд хугацааны хэрэгжилтийг үнэлэх хэлэлцүүлэгт Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Э.Гомбодорж оролцлоо.

**3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл:** Аймгийн хэмжээгээр 18 гэмт хэрэг гарсаны 38.8 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 33.3 хувь нь бусдын өмчийн өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 27.9 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Эхний 1 сард 395 зөрчил илрүүлж, 28 хүн эрүүлжигдэн, 2 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 178, эрүүлжигдсэн хүн 39, баривчлагдсан хүн 8-аар тус тус буурсан байна.

**3.3. Архивын ажлын мэдээлэл:** 5 хөмрөгийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичих, тоо бүртгэлийн програмд оруулах ажлын хүрээнд 4609 хуудас баримтаас 3042 заалт, 12517 хүний нэр, 93PDF файл үүсгэн эх баримтыг холболоо.

Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 3 хөмрөг, 3 данс, 55 хадгаламжийн нэгжийн 2091 хуудас баримтыг сканердаж, 4 хөмрөг 4 дансны 87 хадгаламжийн нэгж, 3687 хуудас баримтыг photoshop програмд засварлалаа.

2 хөмрөгийн 74 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан.

254 иргэний хүсэлтийг хүлээн авч 589 баримт шүүж, 119 хуулбар, 81 лавлагаа тодорхойлолт 50 олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

2018 онд нөхөн бүрдүүлэлт хийх судалгаа хуваарь, иж бүрэн нягтлан шалгаж мэдээллийн технологит шилжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж хөмрөг үүсгэгч байгууллагад хүргүүлсэн. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад мэргэшлийн “Ахлах” зэргийн үнэмлэх олгох тухай судалгаа гаргаж материалыг Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

**3.4. Онцгой байдал:** Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар Улсын нөөцийн өвс тэжээлийг тодорхой хэмжээгээр үнэгүй болон хямдарсан үнээр малчдад олгох шийдвэр гарсантай холбогдуулан өвс тэжээлийг сумдад олгох хуваарийг Аймгийн Засаг даргаар батлуулан хуваарийн дагуу олгож байна.

2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 24 сумын 115 багт үнэгүй олгож буй өвсний 73 %, 50% хямдралтай байгаа тэжээлийн 65 % -г олгосон дүн мэдээтэй байна.

Тэс сум дахь гал түймэр унтраах аврах 57 дугаар ангид байгаа Фотон трактороор далпуу чирч д\ч Д.Дамдинбазараар ахлуулсан 3 албан хаагч Тэс сумаас Баянтэс, Асгат, Баянхайрхан сумын чиглэлд 4 хоногт 250 км хос зам гарган ажиллаж \650л\ түлш зарцуулсан.

Энэ сард график төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтаар аймгийн Орон нутаг судлах музей, Алдартны музей, Хөгжимт жүжгийн театр, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс 4 байгууллагад Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм стандартын хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг зохион явууллаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар объектод байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зайлшгүй байх шаардлага норм, нормативын дагуу байрлуулаагүй, гамшгаас хамгаалах болон гал унтраах шуурхай төлөвлөгөөгүй, ажилчдад гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлага зохион байгуулаагүй, авралтын зам гарцын схем зураг, галын аюулаас урьдчилан сэргийлэх самбар, санамжийг байрлуулаагүй, аваарын гэрэлтүүлэг суурилуулаагүй, цахилгаан ашиглалтын дүрмийг зөрчсөн зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ.

Дээрх зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх 5-12 заалт бүхий заавал биелүүлэх албан шаардлага 3, Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 3, Гал түймэр гарсан тухай акт 1, Шинжээч мэргэжилтний дүгнэлт 1, Зөрчлийн тэмдэглэл 1, Гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзсан 2, Зөрчлийн хэрэг нээсэн 1, зэрэг эрх зүйн баримт бичиг үйлдэж шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газруудын удирдлагуудад танилцуулж зөрчлийг арилгуулах талаар үүрэг чиглэл өгч ажиллаа.

Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуулиудад заагдсанаар орон нутагт гарч байгаа гамшиг осол, гал түймрийн хэрэг зөрчилд хэргийн газрын үзлэг, хойшлуулшгүй ажиллагааг явуулж бүртгэл судалгааг заагдсан хугацаанд Прокурорын газарт хүргүүлэн ажиллаж байна.

**Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг** Улиастай сумын кадастрын зураглалд (1X100000) Галын онц аюултай, 1, 2, 3 дугаар зэрэглэлийн объектууд, усан хангамж, Гал унтраах үндсэн албаны автомашин хүрэлцэн очиход хүндрэлтэй газруудын (зам гарц, мухар гудамжнууд гэх мэт) тэмдэглэгээг хийж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

**Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг** Тосонцэнгэл сум дахь Мөнхийн алба өрхийн эрүүл мэндийн төв, 3,2 дугаар цэцэрлэгийн, ажилтан албан хаагчдад “Ажлын байран дахь галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга”, “Гал унтраагуулын хэрэглээ”, “Галын аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж”, “Аж ахуй нэгж, байгууллагад байх гал унтраах багаж хэрэгсэл” сэдвийн хүрээнд танхимын сургалтыг 4 удаа 2 цагийн багтаамжтай зохион явуулсан сургалтад 76 ажилтан алба хаагчдыг хамруулсан.

#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**4.1. Боловсрол, соёлын чиглэлээр:** “Монгол Улсын ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор Ховд аймагт 2018 оны 01 дүгээр сарын 29-30-ны өдөр зохион байгуулагдсан ”ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ” улсын 2-р зөвлөгөөнд Завхан, Говь-Алтай, Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн БСУГ-ын дарга, мэргэжилтнүүд, ерөнхий боловсролын сургуулийн 220 багш, удирдах ажилтан хамрагдлаа. Зөвлөгөөн нэгдсэн, салбар зөвлөгөөн гэсэн хоёр хэсэгтэйгээр зохион байгуулагдаж, салбар зөвлөгөөн тус бүрээс багш, удирдах ажилтан, мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж гаргаж, эдгээр зөвлөмж, саналуудыг нэгтгэн, ерөнхий боловсролын хууль, дүрэм, журамд тусгуулахаар шийдвэрлэлээ.

“Угийн бичиг хөтлөх уламжлал, ач холбогдлыг таниулах” сургалтын бэлтгэл ажлыг ханган, сургалтанд ашиглах “Угийн бичиг” танилцуулга 220 ширхэг хэвлэн бэлтгэлээ.

“Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг үндэслэн 4 сургуулийн захирал, 9 цэцэрлэгийн эрхлэгчийн сул ажлын байрны зарыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүллээ.

БСУГ-ын хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хүний нөөцийн программд шивж оруулан, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүлээлгэн өглөө.

Хүүхэд харах үйлчилгээг аймгийн ГБХЗХ-ийн газраас БСУГ-т шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/32 дугаартай захирамжаар байгуулагдаж, БСШУС-ын яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу ажлыг хүлээлцлээ.

Хэлний бодлогын орон тооны бус зөвлөл аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/33 дугаартай захирамжаар шинэчлэн байгуулагдаж, зөвлөлийн ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлж байна.

Энэ онд түүхт 80 жилийн ой нь тохиож байгаа Баянтэс, Завханмандал, Тэлмэн, Шилүүстэй сумын ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай байгаа сургалтын тоног төхөөрөмж, тавилгын судалгааг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/117 дугаартай албан бичгээр хүргүүллээ.

Орос хэлний улсын олимпиадын хоёрын давааг БСШУС-ын яамны тогтоосон хуваарьт өдөр 2018 оны 02 дугаар сарын 07-нд ерөнхий боловсролын 3-р сургууль дээр зохион байгуулж, орос хэлний 20 багш, 9-р ангийн 31, 12-р ангийн 14 суралцагч оролцлоо.

Орон нутагтаа ажиллаж амьдарч буй залуу уран бүтээлчдээ дэмжих, тэдний зохиол бүтээлийг олны хүртээл болгох, монгол яруу найргийн өв уламжлалыг хадгалж хамгаалах, шинэ уран бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Утга зохиолын нэгдэл, Залуу зохиолчдын холбоо, Шинэ-Завхан телевиз хамтран “Цастын дуулал” яруу найргийн нэвтрүүлгийг бэлтгэн, сар шинийн баярын өдрүүдээр орон нутгийн телевизээр үзэгчдийн хүртээл болголоо.

Нэвтрүүлэгт аймгийн Утга зохиолын нэгдлийн дэд тэргүүн, Залуу зохиолчдын холбооны тэргүүн Г.Сэр-Одын нэрэмжит шагналт, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч

Б.Баяржавхлан, залуу яруу найрагч Т.Амар-Амгалан, А.Бөхням, Ц.Намуундарь, Э.Сарантуяа, Г.Довчин, Э.Пагмаа нар оролцож, шүлэг яруу найргийн дээжээ өргөлөө.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газар, аймгийн музей, ерөнхий боловсролын 3-р сургуультай хамтран боловсрол, соёлын байгууллагуудын “Монгол өв соёлоо дээдлэхүй” танин мэдэхүйн нэвтрүүлгийг орон нутгийн Air-1 телевизтэй хамтран бэлтгэж, сар шинийн өдрүүдээр үзэгч олондоо өргөн барилаа.

Үндэсний өв соёлыг соён гэгээрүүлэхэд чиглэсэн томоохон уран бүтээл болох “Өндөр гэгээн” дуулалт жүжгийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/75 дугаартай захирамжаар байгуулж, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ханган ажиллаж байна.

**4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд 2 сарын 1-ний байдлаар 136 эх амаржиж, 136 хүүхэд амьд төрж, 32 хүн нас барж, нэг хүртэлх насны хүүхэд 1 эндэж, нийт 26 халдварт өвчин бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрсөн эх 39(40.2%)-өөр, нас баралт 15(88.2%)-аар өсч, халдварт өвчлөл 44(62.9%)-өөр, халдварт бус өвчлөл 805(13.5%)-аар тус тус буурсан байна. 1 сард 1.7 мянган өвчтөнийг 12.1 мянган ор хоногоор хэвтүүлж эмчлэн, 29.2 мянган хүнд амбулаториор үйлчилж, 160 жирэмсэн эхийг шинээр хяналтанд авсан байна.

Сар шинийн баярын өдрүүдэд түргэн тусламжийн дуудлага 295 ирснээс 182 нь насанд хүрэгчдийн 98 хүүхдийн , осол гэмтлийн 3, төрөхийн 6, архи, хоолны хордлогын 6 дуудлага байна. Томуу, томуу төст өвчний амбулаторийн үзлэгт эзлэх хувь 7-р долоо хоногт 11,2%, 8-р долоо хоногт 14,8% байна.

Аймгийн өвөлжилтийн дэлгэрэнгүй судалгаа, өвөлжилт хүндэрсэн болон хүндэрч болзошгүй сумдын судалгааг гаргаж ажлын төлөвлөгөө гарган ажиллаж Эрүүл мэндийн яаманд 14 хоног тутамд мэдээллийг хүргүүлж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн аймгийн комисс хуралдаж 7 байгууллагад үйл ажиллагаа эрхлэх хугацааг сунгасан, 3 байгууллагад тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 2018-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай ЭМС-ын А/15 дугаар тушаалыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж тушаалын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Анхан шатны эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа их эмч, сувилахуйн мэргэжилтнийг хүүхдийн тасагт эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, өвчний түүхэнд ижил мэргэжилтний үнэлгээ хийх зорилгоор ажлын байрны чадавхжуулах сургалтад хамрууллаа.



Алдархаан, Санмаргаз, Сонгино, Их-уул сумын эрүүл мэндийн төвийн эх баригч бага эмчийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн амаржих газарт эх барих, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг сайжруулах ажлын байрны чадавхжуулах сургалтад хамрууллаа.

Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” сэдэвт сургалтыг 5 өдрийн турш зохион байгуулж сумын их эмч, эмнэлгийн мэргэжилтэн 80 албан хаагч оролцлоо.

“Дэлхийн өмөнгийн өдөр”-ийн хүрээнд AIR1 телевизээр “Хавдарт өвчний өнөөгийн байдал, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар” эрүүл мэндийн нэвтрүүлэг бэлтгэж 10 удаа нэвтрүүлсэн. Тэмдэглэлт өдөртэй холбоотой “Осол гэмтлээс сэргийлэх сарын аян”, “Хорт хавдраас сэргийлэх дэлхийн өдөр”, “Сонсгол бууралтын эсрэг дэлхийн өдөр”-ийн хүрээнд “Та энэ тухай бодож байсан уу?” сэдэвт цуврал постер 3 удаа бэлтгэн байгууллагын фэйж хуудас, байгууллагын самбар зэрэгт байршуулсан. Завхан сонинд Хорт хавдраас сэргийлэх зөвлөмж нийтлүүлсэн байна.

#### **4.3.Биеийн тамир, спортын салбар**

Тийн унжлагат хэмээх шороон "Нохой жилийн" сар шинийн баярт зориулсан уламжлалт Үндэсний бөхийн барилдаанаа зохион байгуулж Шилүүстэй сумын харъяат Сумын заан Я. Ишжамц түрүү, Цагаанхайрхан сумын харъяат Сумын заан Д.Цэрэндаш үзүүлж үзэгч түмнээ баясгалаа.

Өсвөрийн цаначдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 дугаар сарын 6-8 ны өдөр Тэс суманд зохион байгуулж Тэс, Баянтэс, Нөмрөг, Түдэвтэй зэрэг 4 сумын тамирчид оролцож багийн дүнгээр Баярсайхан дасгалжуулагчтай Түдэвтэй сум, 1-р байр, Оюунбилэг дасгалжуулагчтай Баянтэс сум 2-р байр, Бүрэнтогтох дасгалжуулагчтай Нөмрөг сум 3-р байр эзэлсэн байна.

“Сагсан бөмбөг 2018” аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 17 байгууллага сумын нийт 230 орчим тамирчин оролцож дүнгээ гаргалаа. Мөн Өсвөр насны Жу-до, Самбо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 754 өсвөрийн тамирчин оролцож Жу-до бөхийн эрэгтэй төрөлд : 4-р Сургууль ЕБС, Эрдэнэхайрхан сумын ЕБС, Отгон сумын ЕБС, Эмэгтэй төрөлд Тэс сумын ЕБС, Түдэвтэй сумын ЕБС, Самбо бөхийн төрөлд: Идэр сумын ЕБС, Тэс ЕБС, Түдэвтэй ЕБС ийн тамирчид шалгарсан байна.

Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан Баруун бүсийн аварга шалгаруулах бага нас, өсвөр нас, идэрчүүдийн үндэсний бөхийн барилдаанд Батбаяр дасгалжуулагчтай 12 бөх оролцож, багийн дүнгээр 3-р байрт орсон байна.

2017 оны Засаг даргын А/28 дугаар захирамжийн хүрээнд 2-р дугаар сарын бүх нийтийг хамарсан спортын арга хэмжээг аймгийн ИТХ удирдан төрийн байгууллагатай хамтран Мөсний шагайн харваа, тэшүүр, бүжиг, Монгол гоёл төрлөөр зохион байгуулсан. Арга хэмжэээнд төрийн байгууллагын 652 албан хаагч оролцсон байна.

#### **4.4.Нийгмийн даатгал, халамж**

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1645 болж, өнгөрсөн оны мөн үеэс 35.0 хувиар буюу 576 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 800 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 48.6 хувийг эзэлж байна.

2018 оны 1 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 35.9 хувиар буюу 591 хүнээр өссөн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 13.4 хувь нь 15-24 нас, 31.2 хувь нь 25-34 нас, 31.5 хувь нь 35-44 нас, 20.4 хувь нь 45-54 нас, 3.1 хувь нь 55-59 нас, 0.4 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 1.3 хувь нь боловсролгүй, 3.0 хувь нь бага, 8.8 хувь нь суурь, 57.1 хувь нь бүрэн дунд, 4.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 20.0 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

**Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:** 2-р сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр 38.6 мянган том мал зүй бусаар хорогдоод байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 7.9 дахин буюу 33.7 мянган толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд хээлтэгчийн хорогдол 6.0 хувь, бог малын хорогдол 96.5 хувь, бод малын хорогдол 3.5 хувийг тус тус эзэлж байна.

Зүүн болон төвийн аймгуудад мал амьтны гоц халдварт өвчний дэгдэлт буурахгүй байгаатай холбогдуулан уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Их-уул сумын Солонготын даваанд цагдаагийн газар, мэргэжлийн хяналтын газруудтай хамтран мал эмнэлгийн хяналтын түр цэгийг ажиллуулж байна.

2018 онд халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, үйчилгээний хөлсийг сумдаар хувиарлан сумдын засаг дарга нартай гэрээ байгуулахад бэлэн болголоо.

Алдархаан, Улиастай, Тэлмэн, Цагаанхайрхан, Цагаанчулуут сумдаас лабораторийн шинжилгээнд 5 дээж эмгэгт материал ирснийг шинжилэхэд Дуут, Галзуу, зэрэг өвчнүүд илэрснийг холбогдох сумуудад нь мэдэгдэж дээрх өвчнүүдтэй тэмцэх заавар журмын дагуу ажиллах үүрэг чиглэл өглөө.

Мал эмнэлэг ариун цэврийн тасагт 232 кг загасны маханд ариун цэврийн магадлан шинжилгээ хийхэд хүнсэнд тэнцэхгүй гэсэн дүгнэлт гарсан. Мөн 2440 кг мах махан бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Мал эмнэлгийн албаны мэргэжилтнүүд өдөр бүр сумдаас мал хорогдлын мэдээг авч холбогдох газруудад нь мэдээлж байна. 2018 оны 2 сарын 28-ны байдлаар аймгийн хэмжээгээр 53045 мал зүй бусаар хорогдсон. Үүнд тэмээ 1, адуу 542, үхэр 1323, хонь 19006, ямаа 32173 хорогдсон байна.

2017 онд ноосны урамшуулалд хамрагдсан 5,8 мянган малчин мал бүхий этгээдийн овог нэр, регистр, дансны дугаарыг баталгаажуулж, алдааг залруулж МХСанд хүргүүлж ажиллаа.

2018 оны хаврын тариалалтад дутагдах үрийн тооцоог гаргаж ХХААХҮЯаманд хүргүүллээ. Энэ онд улаан буудай 82.0 тн, төмс 65.0 тн, хүнсний ногоо 144 кг, төл сонгины үр 1860 кг дутагдаж байна.

“Жижиг дунд үйлдвэрийн ажиглалт судалгаа 2018” -ыг 1 дүгээр сарын 22-ноос 2 дугаар сарын 09-ны хооронд ярилцлагын хэлбэрээр зохион байгуулж энэ арга хэмжээнд 40 аж ахуйн нэгжийг хамруулан судалгааг холбогдох байгууллагад хүргүүллээ.

**Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

**6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** 2018 оны 02 дугаар сард Алдархаан сумын Хаалгын ам буюу Цагаан нуурт 5 уут хужир, 4 боодол өвс тавьж биотехникийн арга хэмжээ авч ажиллалаа.



Аймгийн залуучуудын холбоо БОАЖГазар хамтран “Барьсан загасаа буцаан нууранд нь тавьсанаар амьтны амь таслахгүй байх, зөв зүйтэй загасчлах, загасчлалын спортыг залууст таниулах” зорилгоор аймгийн хэмжээнд анх удаа “Завхан загасчлал” тэмцээнийг загас сонирхогчидын дунд 2018 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Говь-Алтай аймгийн Тайшир сумын “Гэгээ нуур”-д амжилттай зохион

байгууллаа. Тус тэмцээнд 3 хүний бүрэлдэхүүнтэй 5 багийн нийт 15 тамирчид оролцсон.

Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн эко клубын сурагчид “Эко анги” тохижуулах ажилд дэмжлэг үзүүлж аймгийн БОАЖГ-аас цэцгийн сав-10 ш, цэцгийн тавиур 1 ш, гарын авлага 35 ш-ийг өгсөн байна.

2017 оны 9 дүгээр сард аймгийн Засаг дарга Д.Батсайхан Сэлэнгэ аймгийн Шаамар сумын МСҮТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу 36 иргэнийг цэцэрлэгжүүлэгч мэргэжлээр байр, хоол, сургалтын төлбөргүйгээр сургаж байна.



Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн 16 сумын 381,790.06 гектар талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой гэсэн мэдэгдэлд аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн саналыг авах ажлыг зохион байгуулж байна.

**6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 1 сарын байдлаар оны үнээр 1 тэрбум 324.4 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 37.3 хувиар буюу 359.8 сая төгрөгөөр буурсан байна. Нийт үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 61.7 хувийг, хүнсний үйлдвэрлэл 25.8 хувь, хувцас үйлдвэрлэл 10.1 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.4 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 1.2 хувь, бусад үйлдвэрлэл 0.4 хувийг тус тус эзэлж байна.

**6.3. Дэд бүтцийн чиглэлээр:** Улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга байгууламж, их засварын ажлын жагсаалт гаргаж зураг төсөлгүй ажлын зураг төслийг захиалж хийлгүүлэх бэлэн болгох, техникийн нөхцөл бүрдүүлэх, газрын захирамж кадастрын зураг гаргах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Их-Уул сумын 300 хүний суудалтай Соёлын төвийн барилга, Алдархаан сумын 50 ортой цэцэрлэгийн барилга, ГХБХБГ-ын конторын барилгын засварын зураг төслийг “Өлзий-Иш” ХХК аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа ба шаардагдах техникийн бичиг баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.



Улиастай сумын Богдын гол багт Онцгой байдлын газрын ажилчдын 20 айлын орон сууцны барилгыг “Жавхлантаур” ХХК хувийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэн 2018.02.05-ны өдөр улсын комисс ажиллуулан ашиглалтанд орууллаа.

Улиастай сумын 21-р зуун жишиг хорооллын гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр батлуулан Барилга хот байгуулалтын яаманд хүлээлгэн өгч гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдаад байна.

Улиастай суманд жилдээ /192.5 мян.г.кл/ дулаан шаардлагатай байдаг бөгөөд 38 бага оврын халаалтын зуухнууд шаардлагатай дулааныг үйлдвэрлэж байна. Нийт 15454м дулааны шугам ашиглагдаж байна. Эдгээр шугамын 60% нь 2000 оноос өмнө ашиглалтанд орсон насжилт өндөртэй. 40% нь 2000 оноос хойш шинээр хийгдсэн болон, хэсэгчлэн засвар үйлчилгээ хийгдсэн байна. Жилээс жилд дулаан үйлдвэрлэл өсч, цаашдаа дулааны цахилгаан станцыг барьж ашиглалтанд оруулан олон жижиг халаалтын зуухнуудыг нэгтгэн төвлөрсөн системд холбогдож эрчим хүч дулаан хангамжийн зардлыг бууруулах нь нэн тэргүүний зорилт болж байна.

БНСУ-ын хөрөнгө оруулалтаар Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Хэнтий, Дундговь аймгуудад Дулааны станц баригдахаар төлөвлөгдөж байна. Улиастай суманд шинээр баригдах дулааны станцын ТЭЗҮ-г Korea District Heating Enjineering Co.,LTD-д боловсруулагдаж байгаа бөгөөд 2018 оны 01 сарын 22-23-ны өдрүүдэд Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв, Korea District Heating Enjineering Co.,LTD, Mongolia wino energy association компанийн төлөөлөл Улиастай хотод ажиллан шинээр баригдах дулааны станцын хэрэгцээ шаардлага, шугамын трассыг гарган шаардлагатай мэдээллүүдтэй танилцлаа.

Korea District Heating Enjineering Co.,LTD нь Дулааны станцын ТЭЗҮ-г 2018 оны 06 сард Эрчим хүчний яаманд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**